

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/18/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Ховд хот 2022 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn Аудитор: Ц.Гантулга Утас: 70432545 цахим хаяг: gantulga.ts @audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
3. Аудитын тайлан .....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Материаллаг байдал .....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	13
3.8 Аудитын гол асуудал .....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	13
4. Аудитын илрүүлэлт.....	13
4.1 Залруулсан алдаа.....	13
4.2 Зөвлөмж .....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	14

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
НА	Нотлох ажил



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цаибагарав бөг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

УС ЦАГ УУР ОРЧНЫ  
ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН  
ДАРГА А.ЭНХЗАЯА ТАНАА

2022. 02.10 № 2/14  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

001010175

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>94,996,381.11</u></b>	<b><u>87,338,332.42</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	00.00	00.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	94,996,381.11	87,338,332.42
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	62,480,762.07	76,819,156.42
35110	Тусгай зориулалттай материал	62,480,762.07	76,819,156.42
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	32,515,619.04	10,519,176.00
35410	Бичиг хэргийн материал	884,000.00	961,852.00
35420	Аж ахуйн материал	5,534,500.00	2,453,949.00
35430	Сэлбэг хэрэгсэл	7,480,000.00	5,320,000.00
35440	Түлш, шатах тослох материал	18,617,119.04	00.00
35470	Бусад хангамжийн материал	00.00	1,783,375.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>803,406,451.26</u></b>	<b><u>923,104,997.01</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	803,406,451.26	923,104,997.01
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	579,408,044.40	715,791,736.75
39201	Барилга, байгууламж, орон сууц	451,153,017.00	566,770,864.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-46,264,228.99	-68,879,982.91
39203	Авто-тээврийн хэрэгсэл	458,229,391.78	458,229,391.78
39204	Хуримтлагдсан элэгдэл	-390,796,780.04	-400,981,375.64
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	685,414,371.71	618,179,694.84
39206	Хуримтлагдсан элэгдэл	-585,204,307.81	-464,523,250.19
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	14,342,114.00	14,742,114.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7,615,183.25	-7,895,369.13
39217	Ном	149,650.00	149,650.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	223,998,406.86	207,313,260.26
39301	Програм хангамж	275,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-275,000.00	-275,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	258,452,948.50	258,452,948.50
39304	Хуримтлагдсан элэгдэл	-34,454,541.64	-51,414,688.24
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>898,402,832.37</u></b>	<b><u>1,010,443,329.43</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>898,402,832.37</u></b>	<b><u>1,010,443,329.43</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	898,402,832.37	1,010,443,329.43
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,221,235,417.47	1,221,235,417.47
51101	Өмч: - төрийн	1,221,235,417.47	1,221,235,417.47
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-579,671,202.39	-467,630,705.33
51210	Өмнөх үеийн үр дүн	-579,671,202.39	-579,671,202.39
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	112,040,497.06
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	256,838,617.29	256,838,617.29
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>898,402,832.37</u></b>	<b><u>1,010,443,329.43</u></b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,711,070,020.07</b>	<b>1,616,067,689.52</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>135,345,508.07</b>	<b>189,082,257.52</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	135,345,508.07	189,082,257.52
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	135,345,508.07	189,082,257.52
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	135,330,708.07	189,082,257.52
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,575,724,512.00</b>	<b>1,426,985,432.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,542,082,584.00	1,374,772,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,542,082,584.00	1,374,772,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	32,337,440.00	52,212,732.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,043,760.00	1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,793,680.0	42,556,532.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,500,000.00	8,656,200.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	1,304,488.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,304,488.00	00.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,766,428,288.49</b>	<b>1,504,027,192.46</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,766,428,288.49</b>	<b>1,504,027,192.46</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,517,459,215.59	1,427,829,092.46
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,099,467,655.65	1,096,100,200.00
210101	Үндсэн цалин	808,722,446.66	791,588,900.00
210102	Нэмэгдэл	259,300,308.99	228,066,400.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,444,900.00	76,444,900.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	136,972,054.31	147,973,500.00
210201	Тэтгэврийн даатгал	93,397,756.00	104,129,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	11,656,681.00	10,961,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,286,439.00	8,768,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,012,997.00	2,192,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	21,618,181.30	21,922,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	36,356,100.00	34,484,825.00
210301	Гэрэл, цахилгаан	8,587,600.00	7,942,600.00
210302	Түлш, халаалт	24,402,500.00	23,625,025.00

210303	Цэвэр, бохир ус	3,366,000.00	2,917,200.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>57,735,862.00</b>	<b>58,011,511.50</b>
210401	Бичиг хэрэг	4,946,588.40	3,237,900.00
210402	Тээвэр, шатахуун	47,750,060.00	45,060,701.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,531,414.00	2,689,790.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,507,800.00	7,023,120.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>41,000.00</b>	<b>648,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	41,000.00	648,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,378,289.14</b>	<b>3,695,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	653,889.14	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	00.00
210604	Урсгал засвар	724,400.00	3,695,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,755,630.00</b>	<b>3,813,520.00</b>
210702	Дотоод албан томилолт	4,755,630.00	3,813,520.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,877,136.00</b>	<b>6,564,573.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,036,950.00	5,546,373.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	198,000.00	198,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	216,400.00	297,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	116,600.00	116,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	59,400.00	59,400.00
210807	Газрын төлбөр	249,786.00	347,200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>174,875,488.09</b>	<b>76,537,962.96</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	39,507,901.33	7,884,078.04
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,490,000.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	133,877,586.76	68,653,884.92
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>248,969,072.90</b>	<b>76,198,100.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>246,911,916.00</b>	<b>56,456,520.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1,304,488.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	245,607,428.00	56,456,520.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>2,057,156.90</b>	<b>19,741,580.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,057,156.90	19,741,580.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-55,358,368.42</b>	<b>112,040,497.06</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-55,358,268.42</b>	<b>112,040,497.06</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,221,235,417.47	256,838,617.29	-579,671,202.39	898,402,832.37

D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,221,235,417.47	256,838,617.29	-579,671,202.39	898,402,832.37
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,221,235,417.47	256,838,617.29	-579,671,202.39	898,402,832.37
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	118,753,516.10	112,040,497.06
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,221,235,417.47	256,838,617.29	-460,917,686.29	1,010,443,329.43

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,575,724,512.00</b>	<b>1,426,985,432.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,542,082,584.00</b>	<b>1,426,985,432.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,542,082,584.00	1,374,772,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,542,082,584.00	1,374,772,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	32,337,440.00	52,212,732.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,043,760.00	1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,793,680.00	42,556,532.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,500,000.00	856,200.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>783,281,464.00</b>	<b>1,399,874,822.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>783,281,464.00</b>	<b>1,399,874,822.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>649,855,700.00</b>	<b>1,323,676,722.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,089,100,199.10	1,096,100,200.00
210101	Үндсэн цалин	789,161,700.00	791,588,900.00
210102	Нэмэгдэл	268,493,599.10	228,066,400.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,444,900.00	76,444,900.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	147,028,400.00	147,973,500.00
210201	Тэтгэврийн даатгал	103,464,400.00	104,129,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	10,891,000.00	10,961,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,712,800.00	8,768,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,178,200.00	2,192,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	21,782,000.00	21,922,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	36,339,100.00	36,268,200.00
210301	Гэрэл, цахилгаан	8,587,600.00	7,942,600.00

210302	Түлш, халаалт	24,385,500.00	25,408,400.00
210303	Цэвэр, бохир ус	3,366,000.00	2,917,200.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>29,474,560.00</b>	<b>27,543,600.00</b>
210401	Бичиг хэрэг	2,749,300.00	2,084,100.00
210402	Тээвэр, шатахуун	24,266,660.00	18,574,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,738,100.00	3,027,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	720,500.00	3,857,600.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>481,000.00</b>	<b>424,800.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	481,000.00	424,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>7,524,800.00</b>	<b>4,407,900.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,367,500.00	2,310,800.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	185,300.00	166,200.00
210604	Урсгал засвар	972,000.00	1,930,900.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,755,630.00</b>	<b>3,813,520.00</b>
210702	Дотоод албан томилолт	4,755,630.00	3,813,520.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж</b>	<b>9,877,550.00</b>	<b>6,894,602.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,907,150.00	5,876,402.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	198,000.00	198,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	216,400.00	297,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	116,600.00	116,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	59,400.00	59,400.00
210807	Газрын төлбөр	380,000.00	347,200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,789,000.00</b>	<b>250,400.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,789,000.00	250,400.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>248,969,072.90</b>	<b>76,198,100.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>246,911,916.00</b>	<b>56,456,520.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	245,607,428.00	56,456,520.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>19,741,580.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	19,741,580.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>400,000.00</b>	<b>27,110,610.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>400,000.00</b>	<b>27,110,610.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>400,000.00</b>	<b>27,110,610.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>400,000.00</b>	<b>27,110,610.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	400,000.00	27,110,610.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-400,000.00</b>	<b>-27,110,610.00</b>
	Мөнгө , түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	<u>00</u>	<u>00</u>
	Мөнгө , түүнтэй адилтгах эцсийн үлдэгдэл	<u>00</u>	<u>00</u>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан / төгрөгөөр/

	Үзүүлэлт	Тайлант оны
--	----------	-------------

Эдийн засгийн ангилал		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,374,772,700.00	1,355,031,620.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,374,772,700.00	1,355,031,620.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,298,575,100.00	1,298,575,100.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,096,100,200.00	1,096,100,200.00
210101	Үндсэн цалин	791,588,900.00	791,588,900.00
210102	Нэмэгдэл	228,066,400.00	228,066,400.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	76,444,900.00	76,444,900.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	147,973,500.00	147,973,500.00
210201	Тэтгэврийн даатгал	104,129,500.00	104,129,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	10,961,000.00	10,961,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,768,800.00	8,768,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,192,200.00	2,192,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	21,922,000.00	21,922,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	36,268,200.00	36,268,200.00
210301	Гэрэл, цахилгаан	7,942,600.00	7,942,600.00
210302	Түлш, халаалт	25,408,400.00	25,408,400.00
210303	Цэвэр, бохир ус	2,917,200.00	2,917,200.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	8,872,200.00	8,872,200.00
210401	Бичиг хэрэг	1,566,100.00	1,566,100.00
210402	Тээвэр, шатахуун	4,755,100.00	4,755,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,477,400.00	1,477,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,073,600.00	1,073,600.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	424,800.00	424,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	424,800.00	424,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,754,600.00	1,701,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	810,800.00	810,800.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	166,200.00	166,200.00
210604	Урсгал засвар	777,600.00	724,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,017,800.00	1,017,800.00
210702	Дотоод албан томилолт	1,017,800.00	1,017,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	5,913,400.00	5,966,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,895,200.00	4,948,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	198,000.00	198,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	297,000.00	297,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	116,600.00	116,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	59,400.00	59,400.00
210807	Газрын төлбөр	347,200.00	347,200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	250,400.00	250,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	250,400.00	250,400.00

<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	76197600.00	56456520.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	76,197,600.00	56,456,520.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	76,197,600.00	56,456,520.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,374,772,700.00	1,355,031,620.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,374,772,700.00	1,355,031,620.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,374,772,700.00	1,355,031,620.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	95.00	95.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	88.00	88.00
620003	Үйлчлэх ажилтан	06.00	06.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>00.00</b>	<b>97.00</b>
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	00.00	95.00
650010	Гэрээт ажилтан	00.00	02.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>32337440</b>	<b>52,212,232.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>32337440</b>	<b>52,212,232.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	32337440	52,212,232.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	19383160	18,671,400.00
210401	Бичиг хэрэг	1203400	518,000.00
210402	Тээвэр, шатахуун	17679760	13,819,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		1,550,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500000	2,784,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		29,710,610.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5700000	3,400,000.00
210604	Урсгал засвар	0	26,310,610.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1994280	2,795,720.00
210702	Дотоод албан томилолт	1994280	2,795,720.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3670000	1,034,502.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3670000	1,034,502.00
210902	Бараа үйлчилгээний бусад зардал	1590000	
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	0.00	52212232.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	32337440	52,212,232.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24543760	1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	77993680	42,556,532.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		8,655,700.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шатахууны зарцуулалттай холбоотой асуудал дансны хуулийн хэрэгжилттэй зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг аудитор Ц.Гантулга 2022 оны 01 дүгээр сарын 26-наас 2021 оны 02 дугаар сарын 01–ний хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24 -ний өдрийн 43 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Ус цаг уур орчны шинжилгээний төв нь “Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд ус цаг уур орчны шинжилгээний үнэн зөв мэдээллээр хэрэглэгчдийг хангах байгаль цаг агаарын болзошгүй аюул орчны ноцтой бохирдлоос урьдчилан сэргэмжлүүлэх цаг аргаар уур амьсгалын таатай орчныг бий болгох нийгмийн хэрэгцээ хангахад оршино.” гэсэн зорилтыг дэвшүүлэн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- *Нутаг дэвсгэртээ хууль тогтоомжийг хэрэгжүүлэх*
- *Засгийн газрын шийдвэр харьяалах дээд шатны шийдвэрийг гүйцэтгэлийг хянах*
- *Цаг уур орчны шинжилгээний газрын даргын тушаал, шийдвэрийг хэрэгжүүлэх*

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт*
- *Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай*
- *Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/170 тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт*
- *Байгаль орчин шинжилгээний лабораторийн Стандарт хэмжил зүйн ерөнхий газрын шинэ стандартууд*

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ус цаг уур орчны шинжилгээний төвийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Цаг уур орчны хяналт шинжилгээний газрын дотоод аудит 2021 онд тус байгууллагад дотоод хяналт хийгдээгүй байна

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 1,367,680.0 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 136,800.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 10,400.0 мянган төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 141,505.1 мянган төгрөгөөр буюу 8.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.

Оны эхэнд авлагагүй, тайлант онд авлага байхгүй

Бараа материалын дансны үлдэгдэл 94996.4 мянган төгрөг байснаас тайлант хугацаанд тусгай зориулалттай материал, бичиг хэргийн материал, аж ахуйн материал, сэлбэг хэрэгсэл, түлш шатахуун тослох материал, хүнсний материал, бусад хангамжийн материалуудыг 34130.5 мянган төгрөгөөр худалдан авсан, үнэ төлбөргүйгээр 27,840.4 мянган төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 69,629.0 мянган төгрөгийн материалыг зарцуулжээ. Оны эцэст 87,338.3 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө оны эхэнд 1,064,610.0 мянган төгрөг, тайлант онд худалдаж авсан 400.0 мянган төгрөгийн лабораторийн ширээ, үнэ төлбөргүй хүлээн авсан барилга байгууламж 90807.3 мянган төгрөг, машин тоног төхөөрөмж 8,343.5 мянган төгрөг, программ хангамж 275.0 мянган төгрөг, Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2021 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн А/146 тоот тушаалаар барилгын их засвар сайжруулалтаар 24,810.6 мянган төгрөг, аймгийн Засаг даргын 2021 оны 4 дүгээр сарын

19-ний өдрийн А/203 тоот захирамжийн дагуу нэмэлт санхүүжилтээр зөөврийн компьютер 1900.0 мянган төгрөгөөр худалдаж авсан байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө 141,505.1 мянган төгрөгөөр буурсан нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас 2021 оны 11-р сарын 11-ний өдрийн 528-р тогтоолоор акталсан хөрөнгө 7,130.4 мянган төгрөг, 2021 оны 508-р тогтоолоор 13 нэр төрлийн 17 ш 133,274.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоон 62,927.4 мянган төгрөг болгосон өөрчлөлт орсонтой холбоотой оны 923104.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байна.

Тайлант онд өр төлбөр үүсээгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 898,402.8 мянган төгрөг байсан ба оны эцэст 1,010,443.3 мянган төгрөг болж тайлант онд 112040.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 112,040.5 мянган төгрөг болсон байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,374,722.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,355,031.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж төвлөрүүлэх шилжүүлэг 19741.0 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчаас тус байгууллагын төсвийг 1,374,722.6 мянган төгрөгөөр батлан ирүүлжээ.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд 1,374,722.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,374,722.6 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжилтийг зарцуулсан байна

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,374,722.7 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтээр 52212,7 мянган төгрөг нийт 1,426,985.4 мянган төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтэрсэн хэмнэсэн зардал байхгүй байна

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн орлогоор ЗДТГ-аас 1,000.0 мянган төгрөг, дээд шатны байгууллагаас 42,556.5 мянган төгрөг, бусад ТЕЗ-аас хуваарилсан 7337.7 мянган төгрөг үйл ажиллагааны орлогоос 1,318.5 мянган төгрөг, нийт 52,212.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж холбогдох үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

АДБОУС 701.8-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 148 мэдээллийг хугацаандаа оруулсан, төсвийн гүйцэтгэлийн хөл дүнг нэгтгэж мэдээлээгүй, тайлбар хэсэгт мэдээлэл оруулаагүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 117112.5 мянган төгрөгийн орлого /санхүүжилт/-ыг, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий төрийн албан хаагчдын нэг удаагийн тэтгэмж болох 68116.5 мянган төгрөг, Ховд цахилгаан түгээх ХХК-ны цахилгааны худалдан авалт 25646.6 мянган төгрөг, бүгд 210875.6 мянган төгрөг дутуу мэдээлсэн байна.

Дээрх цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн орлогын 23 ажил гүйлгээг шилэн дансны сайтад байршуулаагүй байсныг аудитын явцад залрууллаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1,212.1 мянган төгрөгийн 2 төлбөрийн актыг төсөвт бүрэн барагдуулж, 6,491.5 мянган төгрөгийн албан шаардлагын зөрчлийг арилгуулан, 1 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

#### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал хандуулахуйц асуудал байхгүй болно.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 1098.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэнд 1 зөвлөмж өглөө.

### **4.1 Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Шилэн дансны тухай хуулийн 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”-ийг 7 хоногийн дотор мэдээлнэ гэсэн заалтыг зөрчин төсвийн санхүүжилтийн орлогыг мэдээлээгүй байна.

**Шийдвэрлэсэн нь** Байгууллагын шилэн дансны сайтад 23 удаагийн ажил гүйлгээг нөхөж мэдээлүүлсэн.

#### 4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. **Шатахууны зарцуулалттай холбоотой асуудал**

**1.1 Илрүүлэлт:** Нягтлан бодогчийн хяналтгүйгээр зөвхөн байгууллагын даргын зөвшөөрлөөр 494 литр 1,098.8 төгрөгийн бензин зарцуулжээ. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-д “анхан шатны баримт” гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог, 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно.” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

**1.2 Өгсөн зөвлөмж:** Байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтдаа бензиний зөвшөөрөл олгох бичгийг тусган албажуулж нягтлан бодогч, нярав нарын хяналтаар олгож хэвших

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Ус цаг уур орчны шинжилгээний газар	1	1098.0							1	1098.8

#### ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР